

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Эрдэм шинжилгээний бичиг

Боть XLI (483)

Улаанбаатар

2017

МОНГОЛЖИНЧУУДЫН НЭРИЙН ТУХАЙ

Чимэг

Агуулгын товч: Хүний нэр нь тэмдгийн шинжээр илэрсэн, нийгэм ба соёлын агуулга болно. Энд бид монголжин оронд хийсэн хээрийн судалгааны материалдаа суурилан, монголж инчуудын нэрийг насны хэмжээгээр шатлан хуваан судалж, тэдний монгол, хятад хоёр нэр авах ёсон, хятад нэр авах уламжлалын монголжинчуудын дунд гүн үндэслэсэн шалтгаан зэргийг хайн сувэгчилсэн байна.

Түлхүүр үг: монголжинчууд, монгол нэр, нэрлэлтийн онцлог

Хүний нэр бол хэлний үзэгдэл мөртөө бас соёлын үзэгдэл мөн. Хүний нэрийн судлал нь нэр зүйд багтах бөгөөд үгсийн сангийн судлалын чухал нэг салбар шинжилгээ болно гэж эрдэмтэд үзэцгээдэг байна. Хүний нэр нь нэг үндэстний сэтгүйн хэлбэр, хэлний онцлог ба үндэстний соёл сэтгэлгээ зэрэг талыг зохих хэмжээгээр харуулдаг байна. Иймээс энэ талын судалгаа нь бас үндэстний соёлын хөгжилд чухал үйлдэл үзүүлдэг. Швейцарийн нэрт хэлний эрдэмтэн Ф.де Соссюр “Хүний нэр нь нийгмийн түүх, зан дадгал, соёлын ойлгогдохуун зэрэгтэй нягт харьцаатай бөгөөд зохих түүхэн шатан дахь соёл ба соёлын дотоод шинжийг тусгаж байдгаас хүний нэр нь тэмдгийн шинжээр илэрсэн, нийгмийн ба соёлын агуулга юм” (索绪尔, 2003:39) гэж хэлсэн байдал. Ийнхүү хүний нэр нь соёлын ачаалагч гэмээн танигдсаны хувьд тухайн нийгмийн янз бүрийн сураг зангийг илрүүлж байдал.

Энд бид Фүшин монгол үндэстний өөртөө засах сянийн (цаашид монголжин гэнэ) монголчуудын нэрд ямар онцлог шинжтэй байгаа, мөн хойшдын хандаш нь ямар байх зэрэг талаар анхаарч судалсан зүйлээ танилцуулж байна. Материал цуглуулахдаа бид монгол үндэстэн хамгийн илүү төвлөрөн суугаа Фүшин сянийн хоёр айл, даруй Шар-Ус балгасны Цахар айл ба Гэгээнсүм балгасны Цагаанхад айлын өрх амын дансанд тэмдэглүүлсэн хүний нэрийг тухайн айл гацааны зөвлөлөөс цуглуулж авсан бөгөөд монголжиний монгол сургуулийн гурван ангийн сурагчдын нэрсэд тусгай судалгаа хийсэн байна. Тэрчлэн тухайн газрын хүмүүсийн багын нэрийг мөн дээр дурдсан хоёр айлаас бүртгэж авсан байна. Бодитой тоо гэвэл Гэгээнсүм балгасны Цагаанхад айлын 363 хүн, Шар-Ус балгасны Цахар айлын 381 хүн, сянийн монгол сургуулийн гурван ангийн 151 сурагч, нийт 895 хүний нэрд судалгаа хийсэн байна. Тэгээд судалгааны материалдаа суурилан, насны хэмжээгээр шат хуваан шинжилсний дүнд нэр өгөх зан үйл, нэрлэлтийн онцлог зэргийн өөрчлөлтийн байдал буюу цаг үеч шинжтэй танилцсан төдийгүй, монголжиний адил бус цаг үе дэх нийгмийн өөрчлөлт, бусад үндэстэн лу гээгийн хэлний ойртолцоо ба соёлын солилцоог ч зохих хэмжээгээр ойлгосон байна.

Цаг үе	1949 оноос өмнө	1950—1979 он	1980 оноос хойш	Бүх нийт
Нийт нэр	128	615	152	895
Монгол нэр	18	3	11	31
Хятад нэр	110	612	141	864
Харьцал (монгол,хятад)	14.1%:85.9%	0.5%:99.5%	7.2%:92.8%	3.5%:96.5%

Нэг. Хятад нэр авах уламжлал

Гацааны зөвлөлөөс хангасан хүн амын бүртгэлийн хүснэгтээс үзэхэд, монголжинчуудын албан ёсоор данслуулсан нэрийн ихэнх нь бүгд хятад нэр байлаа. Бид чөлөөлөгдхөөс өмнө (1949 оноос өмнө), улс байгуулагдсанаас өөрчлөлт нээлтийн эхний үе болтол (1950-1979 он), өөрчлөлт нээлтийн эхний үеэс одоо болтол (1980 оноос нааш) гэж гурван шат үе хувааж, монголжинчуудын албан ёсоор данслуулсан нэрийг бүртгэж үзсэнд дараахдүнгийг олсон байна.

Дээрх хүснэгтээс үзхэд монголжинчууд нэлээд эртнээс хятад нэрээр данслуулах нь олширсон (1949 оноос өмнө 85.9%) бөгөөд 1950-1979 оны хоорондох 20 жилд бараг бүх ардаараа хятад нэр (99.5%) авч байсан ба 1980 оноос нааш хятад нэргээ хүмүүсийн харьцаа бага зэрэг доошилсон боловч мөн зонхилох тоог эзэлж байна (92.8%). Энэ нь хятад нэр авах уламжлал тэдний дунд гүн үндэслэсэн бөгөөд ялангуяа их орчин тойрондоо зохицох шаардлагаас ийм болсон гэдгийг харуулж байгаа бололтой. Ер нь монголжинчуудын хятад нэр овог авах болсон шалтгаан олон талтай боловч түүхийн талын шалтгаан байхыг үгүйсгэхийн аргагүй юм.

Бодитойгоор хэлэхэд, XX зууны эхнээс монголжин нутагт зарим сургууль эхлэн байгуулагдаж, энэхүү журмын сургуульдаа ойр хавийн бичиг соёлтой хятад хүнийг залж хичээл оруулдаг байжээ. Тэгээд хятад багш нь сурагчиддаа хятад нэр өгдөг болохоор монголжин орон чөлөөлөгдхөө болтол тухайн орны олонх монгол эрэгтэйчүүд бүр хятад нэргээ болжээ. Мөн 1948 оны газар шорооны өөрчлөлтийн хөдөлгөөний үед дээд шатнаас томилсон катарчуудын олонх нь хятад үндэстэн бөгөөд монгол хэл мэддэггүй буюу бага сага л мэддэг хүмүүс байв. Энэхүү хөдөлгөөнд оролцсон тухайн газрын ажилтан дарга нарын олонх нь монгол үндэстэн боловч хятад үсэг бараг таньдагтүй. Ингээд газар тариа хуваарилах ба данс бодох зэрэг бодитой ажлын явцад монгол нэргээ тосгоны ардын нэрийг хятадаар бичихдээ охор дөхөм шиг нь хятадаар авиаан тэмдэглэж, нэлээд урт бөх дуудлага нь арай төвөгтэй монгол нэрийг шууд хятад нэр болгон өөрчилсөн гэнэ.

Хоёр. Монгол нэрийн учир

Дээр танилцуулсан мэтээр монголжинчуудын өрх амын дансан дахь нэrd хятад нэрийлэнх тоог эзлэх боловч тэдний олонх нь хоёр нэргээ гэдгийг судалгаагаар олж мэдсэн юм. Тэгвэл тэдний албанд данслуулсан нэрээс гаднах нөгөө нэг нэр нь чухам ямар нэр вэ? Тэр нэр нь ямар онцлогтой байдаг бол? Судалгааны дунд тэдний нөгөө нэр нь анх эхэндээ багын нэрийн шинжтэй боловч нутаг усандаа буюу гэр бүл төрөл садны хоорондоо бол насан туршдаа байнга хэрэглэгддэг онцлогтой байна. Судалгаанд бүртгэгдсэн 895 хүнээр жишээлхэд, цөөн хэдхэн хүнд ганц нэргээг гаргавал бусад нь бүр хоёр нэргээ бөгөөд хоёр дахь нэрийн олонх нь харин монгол нэр (төвд нэр болон монголжсон хятад нэр багтана) байлаа. Гэхдээ тэдний ийм нэр нь цаг үеийн онцлогоор товоим байдаг. Тухайлбал ахмад идэр үеийнхний

нэрд “Мөнх, Тавинтай, Наранчимэг, Алданхүү, Бадам, Бадамхуар, Зул, Гарьд, Гарьдшууу, Бүрнбаяр, Баян-Өлзий, Эрдэнэ, Баянсан, Бүжиг, Мандуул, Залгаа, Залган, Насанбөх, Овоо, Тэгшбаяр, Манаа, Уржих, Зууннамар, Баяннамр, Сайн-Өлзий, Журамт, Голт, Хурдхүү, Насан-Урт, Цагаанбар, Хасчулуу, Хас-Эрдэнэ, Намраа, Түвшин, Дагуулаа, Хүүзаяа, Дүүзаяа, Хор ио, Үндэс, Муу-Охин, Өлзий, Сайнзаяа, Болчулуу, Харбар, Ширэмбөх, Сайнжилт, Тогтолч, Тогтох, Давхарбаяр, Гэрэл, Сайжрах, Хөхбар, Баатар” гэх мэтийн монгол нэр олон тохиолддог бол “Самбуу, Ращдэлэг, Сээрэн, Цоймолжав, Дамрин, Гэлэгсамбуу, Дамринжав, Лодонжав, Товчинжав, Луванжав, Намдаг, Маанийжав, Гомбураш, Надмид, Чимэд, Гарвасэнгэ, Ороомаа, Гончигжуннай, Тойнхоржав, Лагжээ” зэрэг төвд нэр голдуу дээр зууны гуч дечеөд оны үед төрсөн ахмадууд буюу зарим нэг лам гаралтай хүний нэрд харагдаж байна. Мөн “Тэгшмаа, Шяю Нохой, Шюожав, Шинэжав, Мицэцэг, Алд-Осор, Шюобэр, Өлзийсэнгэ” гэх мэтийн монголтөвд, хятад-монгол, төвд-хятад холимаг нэр цөөн байна. “Дайшяо, Линшяо, Мэйхуа, Жинхүү, Гэншияо, Лайшияо, Дайшиюн, Тянхүү, Хайтан, Тянсан, Мансан, Жинхуар, Босан, Шуанши, Шуанбо, Хаймэй, Чиншан, Мэйрун” мэтийн монголжсон хятад нэр ч нэлээд бий.

Сүүлийн үеийн байдал гэвэл, монголжинчуудын үндэстний хэл соёлоо дээдлэн хамгаалах үзэл ухамсын дээшлэхийг дагалдан, үр хүүхдэдээ гоц сайхан монгол нэр өгөхийг санаачлан сэдэж байгаа нь тодорхой ажиглагдана. Жишээлбэл, “Айзам, Цаснаа, Мандаа, Өглөө, Солонго, Алмаас, Сайхнаа, Тэргүүн, Шинэ, Дорноо, Цоморлиг, Давалгаан, Соёл, Сацрал, Саруул” гэх мэтийн шинэ цаг үеийн онцлог бүхий монгол нэртэй сурагчид олширч байна. Гэхдээ ийм нэрийн бас нэг онцлог гэвэл олонх байдалд тэдний хятад нэртэй нь утгын холбоотой байдаг. Жишээлбэл “Соёл-包文博, Мандаа-包兴, Саранчимэг-齐月英, Өглөө-包晨旭, Солонго-乔虹, Цасанцэцэг-邢雪莲, Сайхнаа-宫美惠” гэх мэт. Мөн 乌兰 (Улаан), 白音 (Баян) гэх мэтчилэн шууд монгол нэрээрээ өрөх амын дансанд бүртгүүлсэн байдал ч мэр сээр харагдаж байна. Зарим эцэг эхчүүд үр хүүхдэдээ багын монгол нэр хайрласангүй бол цэцэрлэг буюу сургуульд орох үед ангийн багш буюу хэл бичгийн багшаас нь монгол нэр өгөх үзэгдэл бас байдгийг дурдууштай.

Ерөнхийд аваад хэлэхэд, монголжинчууд хятад, монгол “хоёр нэрийн дурэм”-ийг наад зах нь дээр зууны эхний хагасаас эхэлж хэрэгжүүлсээр эдүгээ болсон байна.

Номзүй

索绪尔：“普通语言学教程”，北京商务印书馆，2003年